

ТҮМЭНЦОГТ СУМЫН 2021 ОНЫ 02ДУГААР САРД ХИЙСЭН АЖЛЫН МЭДЭЭ

Төрийн удирдлагын чиглэлээр:

- Сар шинийн баярыг угтан аймгийн сайн малчин 1, сумын сайн малчин 2, энх сүрэгтэн 2, төл таван эрдэнэ 2, шилдэг уяач 1, шилдэг унаач 1, шилдэг харваач 1, мянгат малчин 2 шалгарч шагнал гардуулах, хүндэтгэл үзүүлэх ажиллагааг зохион байгуулж Засаг даргын нөөц сангаас 2.1 сая төгрөгийг зарцуулсан.

- Аймгийн Засаг даргын албан даалгаврыг хэрэгжүүлэх хүрээнд байнгын асаргааны ахмад настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүнс, тэжээлийн дэмжлэг 2,5 сая төгрөг зарцууллаа.

- Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх халдвар хамгааллын хувцас, хэрэглэл, тусгаарлан ажиглах байр тохижуулах үйл ажиллагаанд 3,7 сая төгрөг зарцуулж бэлтгэл бэлэн байдлыг хангасан.

- Нэгдсэн хогийн цэгийг “Ус-Дулаан” ААТҮГазар хариуцан 1,3 сая төгрөгийн шатахуун зарцуулсан түрж цэгцлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

- Засаг даргын захирамж 16, ЗДТГ-ын даргын тушаал 3, ирсэн бичиг-13, Засаг даргын явсан бичиг-10, ЗДТГ-ын даргын явсан бичиг-6, өргөдөл гомдол-0, Төрийн үйлчилгээний оператороос 7 төрлийн лавлагаа өгч иргэн төвтэй-төрийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Хууль эрх зүйн чиглэлээр:

Ковид-19 цар цахалтай холбоотой Улсын Онцгой комиссын албан даалгавар, ЗГ-ын тогтоол, аймгийн Засаг даргын захирамжийн хүрээнд холбогдох арга хэмжээг авч цахимаар 56 төрлийн мэдээллийг сумын 3 группээр дамжуулан иргэдэд хүргэсэн.

Шинэчлэгдэн найруулагдсан хууль тогтоомжийн талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд цахимаар 6 төрлийн мэдээлэл 20 гаруй удуугийн давтамжтай хүргэсэн.

Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах орон тооны бус зөвлөл байгуулж худалдаа үйлчилгээ эрхэлдэг ААНэгжүүдэд хяналт тавьж, заавар зөвлөмж, сургалт зохион байгуулах төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Эдийн засаг, төсөв санхүүгийн бодлогын хүрээнд:

Шилэн дансны тухай хуулийн 5-р зүйлийн 5,3 дах заалтыг хэрэгжүүлэх үүднээс 2021 оны 02-р сарын мэдээг шилэн дансны вейб сайтад байршуулсан Сангийн яам болон холбогдох хэлтэс агентлагт хувиарын дагуу мэдээг хүргүүлэн ажилласан

СХСангийн программд зээлдэгч нарын мэдээллийг шивж оруулсан. Зээлдэгч 29-н иргэнд мэдэгдэл хүргүүлсэн.

Төсөвт байгууллага болон ААТҮГ, ОНӨҮГ, сангуудын 12 байгууллагын санхүүгийн жилийн эцсийн нэгдсэн тайланг Сангийн яамны сайтад цахимаар илгээсэн.

Сангийн яамны сайтад 43-н ААНБайгууллага болон төрийн бус байгууллагын санхүүгийн жилийн эцсийн тайланг хуулийн хугацаанд илгэхэд хяналт тавьж ажилласан.

Татвар,Нийгмийн даатгалын тайланг цахимаар болон цаасан тайланг баталгаажуулан тооцоо нийлж , ажилтан албан хаагчдын татвар төлөгчийн дэвтэрт бөглөлт хийсэн.

Статистикийн хэлтэст жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дэлгэрэнгүй болон хураангуй сонгогдсон байгууллагуудын үйл ажиллагааны мэдээллийг ААНБ-1 –ээр 8-н байгууллага, ААНБ-2 маягтаар 16-н байгууллага хамрагдаж хугацаанд хүргүүлсэн.

Орон нутгийн орлогын биелэлт: /02 сарын дүнгээр мян.төг /

• Үйл ажиллагааны орлого	280,0
• Шууд бус орлого	
• Хөрөнгө борлуулсаны орлого	
• Хөрөнгийн орлого	1219,8
• Буу	
• Улсын тэмдэгтийн хураамж	635,0
• Хог хаягдал	1200,0
• Хүү торгуулийн орлого	2440,0
• ТТАМ	
• Бусад нэр заагдаагүй орлого	20000,0
• Ан амьтны нөөц ашигласаны төлбөр	
• Газар	
• Дүн	25774,8

Хөдөө аж ахуй:

- Сумын хэмжээнд өвөлжилт хүндэрч 2 багийн 92 өрхийн 61249 мян.толгой мал өвс тэжээлийн хомсдолд орж 150 тн өвс, 30 тн хивэг тэжээл шаардлагатай байгааг Аймгийн ХХААГазарт хүсэлтээр хүргүүлснээс Улсын нөөцийн хивэг задарч малчин мал бүхий өрхөд хивэг тэжээлийг олгоод байна.

- Сумын жишсэн хүн ам болон хэрэгцээ хангамжийн судалгаа, хүнсний худалдаа эрхлэгч 14 ААНэгж дэлгүүрүүдээс хүнсний нөөцийн мэдээ болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн мэдээг тогтмол авч нэгтгэн ХХААГазарт хүргүүлэн ажиллаж байна. Мөн COVID -19 цар тахалтай холбогдуулан хүнсний худалдаа эрхлэгч аж ахуйн нэгж дэлгүүрүүд цаасан бүртгэл болон QR кодыг ашиглан үйлчлүүлэгчдийн бүртгэлийг хийж хэвшээд байна. Хүнс тээврийн 2 тээврийн хэрэгсэлд QR код олгосон.

- Ахуй үйлчилгээ эрхлэгчдийн судалгааг Аймгийн ХХААГазрын мэргэжилтэнд хүргүүлсэн. Мөн сум хөгжүүлэх сангийн 29 зээлдэгчид албан мэдэгдэл хүргүүлж Монгол банкны цахим санд шивэлт хийгдэж байгааг танилцуулан гарын үсэг зурж баталгаажуулсан.

- Сумын хэмжээнд том малын зүй бусын хорогдол тэмээ – 1, адуу – 140, үхэр - 210, хонь -707, ямаа – 761, нийт – 1819 толгой мал хорогдож сумын нийт малын 1,3%-ийн хорогдолтой байна.

Мал эмнэлэг:

- Өөрийн суманд байгаа отор нүүдлийн судалгаа гарган аймгийн мал эмнэлгийн газарт хүргүүлээд байна.

- Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор төв зам дагуу дамжин өнгөрч байгаа техник болон мал амьтны шилжилт хөдөлгөөнд хяналт хийн ажиллаж байна.

- Улаанбаатар хот хооронд зорчсон хүнс тээврийн 7 тээврийн хэрэгсэлд ариутгал халдваргүйтгэл хийгээд байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Хөдөлмөр, нийгмийн халамжийн чиглэлээр:

- Ажил хайгчаар бүртгүүлэх хүсэлт гаргасан 2 иргэний бүртгэлийг мэдээллийн санд бүртгэсэн.
- Сумын иргэдэд Хөдөлмөр эрхлэлт болон Халамжийн чиглэлээр хэрэгжиж байгаа үйл ажиллагааг суртачилах, мэдээ мэдээлэл өгөх зорилгоор “Хөдөлмөр, халамж Түмэнцогт сум” нэртэй цахим хаяг нээж иргэдэд мэдээ, мэдээлэл хүргэж ажиллаж байна.
- Өрхийн мэдээллийн санд шинэ төрсөн 2 хүүхдийн мэдээллийг мэргэжилтэнд хүргүүлж бүртгүүлсэн.
- АДЗөвлөлийн хурлаар 2 удаа хуралдуулж ахмад настны асаргааны тэтгэмжид хамрагдах хүсэлтэй 1 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргааны тэтгэмжид хамрагдах хүсэлтэй 1 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асаргааны сунгалт 1 иргэний материалуудыг тус тус хэлэлцсэн.
- Эхийн алдар 1 болон 2 дугаар одонд хамрагдсан 242 иргэдийг мэдээллийн сантай тулгаж бүрэн олгож дууссан.
- “Хамтын хүчээр ажлын чанараа сайжруулья” сарын аяны удирдамжийн дагуу Онгон сумын ХЭХАХМэргэжилтэн М.Мөнх-Эрдэнэтэй ажиллах ажлын төлөвлөгөө гаргаж төлөвлөгөөний дагуу өдөр бүр утсаар холбогдож харилцан мэдээлэл солилцож туршлага судалж өдөр тутмын ажилдаа хэвшүүлж ажиллаж байна.
- Ахмад настны тэтгэвэр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэрийн үйлчилгээтэй нийт 43 иргэнийг утасны дугаар дансны мэдээллийг Ехаламж мэдээллийн санд бүртгэж оруулсан.
- Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлэх тендер зарлагдсныг сумын 8 аж ахуйн нэгж байгууллагад мэдэгдэж 2 аж ахуйн нэгж байгууллага оролцсон.
- Албан байгууллагын харъяалалгүй 224 ахмад настны дансны болон утасны дугаарыг харилцагч банкуудаас авч wais мэдээллийн санд бүртгэж олгосон.

Цэцэрлэг:

- БШУЯ, Монголын телевизүүдийн холбоотой хамтран зохион байгуулж буй теле хичээлийн хуваарийг анги бүлгүүдийн группд байрлуулан, үзэх хувь хамрагдалтыг нэмэгдүүлэхэд анхаарч эцэг эх асран хамгаалагчидтайгаа утсаар болон цахим хуудсаар нь холбогдон мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх зэргээр хамтарч ажилласан.
- Тус байгууллагад 37 дах жилдээ тасралтгүй ажиллаж байгаад гавьяаныхаа амралтанд гарах гэж буй БТА багш Б.Энхцэцэгийг алдаршуулах ажлыг зохион байгууллаа
- 2020 онд төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан мөн гадаад дотоодын зээл тусламж, хандив, бэлэглэлээр бий болсон хөрөнгийг данс бүртгэлдээ тусган, 2020 онд шинээр авсан болон бэлтгэсэн, данснаас хассан хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр бүртгэн баримтжуулж өмч хөрөнгийг бүртгэлжүүлэх, зурагжуулж өмч эзэмших картжуулан баталгаажуулж өгсөн.
- Туслах багш нарын ур чадварыг дээшлүүлэх компьютерийн сургалт, багш ажилчдын монгол бичгийн боловсролыг дээшлүүлэх цахим сургалт, тогооч нар хүүхдийн хоолгы цэсэнд баяжилт хийх, мэргэжлийн ур чадвараа нэмэгдүүлэх дадлага ажил хийх зэрэг дотоод сургалтуудыг зохион байгуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий боловсролын сургууль:

- БСУГазрын ажлын өгсөн үүргийн дагуу 02 сарн 18 өдрөөс 12-р ангид 7 хичээлээр, 1,2,5-р ангид Математик, Монгол хэлний хичээлээр, 9-р ангид Монгол хэл, Математик, Англи хэлний хичээлээр давлага өгч 178 сурагч, 18 багш хамрагдсан байна.

- Хүн хоорондын зай барих, тэмдэг, тэмдэглэгээг 100 ширхэгийг хэвлэн гаргаж хичээлийн 1,2-р байранд байрлуулсан байна.
- ЭМТөвтэй хамтран хичээлийн 1,2-р байр, дотуур байранд Агаарын ариутгалыг хийсэн.
- Суралцагчдын байршлийн судалгааг гарган БСУГазарт Байгууллагын 2020 оны тайланг Аймгийн ЗДТГазарт, байгууллагын эд хөрөнгийг зурагжуулан тайлан гаргаж аймгийн өмчин газарт хүргүүлээд байна.

ЭМТөв:

- Эрүүл мэндийн төвийн амбулаториор 524 иргэн, алсын дуудлагаар 11 , ойрын дуудлагаар үйлчлэгч үйлчлүүлж, 18 иргэн хэвтэн эмчлүүлсэн байна. Товлолт дархлаажуулалтанд 100%, В гепатитын эсрэг сайн дурын дархлаажуулалтанд 100 % тус тус хамруулсан.
- Энэ сард голомт бүхий бүс нутгаар зорчсон 84 иргэнийг гэрийн ажиглалтанд авч тогтмол хянаж түргэвчилсэн оношлуураар шинжилгээнд хамруулж ажиллав.
- Ариутгал, халдваргүйтгэлийг:
 - Шинжилгээнд явсан автомашинд 7 удаа -56мкв
 - Спорт заал-403мкв
 - Соёлын төв-166мкв
 - Амбулаторит-83мкв
 - Ачаа тээврийн 4 машинд - 32мкв
 - Ерөнхий боловсролын сургуульд 16000мкв
 - Дэлгүүрүүд ААН –820 мкв талбайд тус тус халдваргүйтгэл хийсэн
- Давсан бадрах постонд 1 бага эмч дайчлагдан ажиллаж нэвтэрсэн бүх иргэдээс түргэвчилсэн оношлуураар шинжилгээ авч мэдээллийг ЭМТ-д ирүүлэн гэрийн ажиглалтанд авч ажиллаласан.Ковид-19 халдварын бэлэн байдлыг ханган нөөц бүрдүүлэлтэд 8,5 сая төгрөг зарцуулсан.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

Э.ШҮРЭНЦЭЦЭГ /ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН/